



**“ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ
БАЙГУУЛАМЖ” ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар A/38

Замын-Үүд сум

Журам батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.3, 28.1.6 дэх заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 01 дугаар тогтоол, Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөдөлмөрийн дотоод журмын 2.4.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ажилтан нарт “Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалт, эдэлгээний хугацааг тогтоох, захиалга хангамжийн ажлыг зохион байгуулах, хяналт тавих журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн жагсаалт, эдэлгээний хугацаа”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Стандартын шаардлага хангасан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, чанар, ашиглалт, эдэлгээний хугацаа, олголт, хэрэглээ зэрэгт хяналт тавьж ажиллахыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд үүрэг болгосугай.
3. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, бууршгүй нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан /Д.Мөнхнаран/, аж ахуйн нярав /Б.Март/ нарт үүрэг болгосугай
4. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл худалдан авах хөрөнгийн санхүүжилтийг цаг тухайд нь олгож байхыг ерөнхий нягтлан бодогч /Б.Дэлгэрдалай/-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ерөнхий инженер /Б.Мөнхзаяя/-д даалгасугай.
6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн A/19 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

Г.ГАНСҮХ



“АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС, ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ,
ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЦААГ ТОГТООХ, ЗАХИАЛГА ХАНГАМЖИЙН АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ”

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ажилтан нарт ажил мэргэжлийн онцлогт тохирсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн /цаашид ХАБЭА гэх/ стандартад нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, нэр төрлийг тогтоох, ажлын ачаалал, үйл ажиллагааны онцлогоос хамааруулан эдэлгээний хугацааг тогтоох, ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийг худалдан авах, олгох, тэдгээрийн эдэлгээний байдалд хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгсэл нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандартаар тодорхойлогдсон шаардлагад нийцсэн байх ба ажлын байрны онцлогт тохирсон үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйл болон цаг агаарын нөлөөллөөс хамгаалах зэрэг шаардлагыг хангасан байна.

1.3. Энэхүү журмыг Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нийт ажилтан дагаж мөрдөнө.

1.4. Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ажилтны ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл дээр байгууллагын товчилсон нэр, эмblem заавал байна.

1.5. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл нь Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгө тул ажилтан нар ариг гамтай ашиглах төдийгүй ажлын бус цагаар өмсөж хэрэглэх, зарж борлуулах, үрэгдүүлэхийг хориглоно.

1.6. Эсгий гутал, усны гутал, борооны цув нь агуулахад бууршгүй нөөцтэй байна.

ХОЁР. АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС, ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ
ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Ажлын тусгай хувцас нь улирал цаг агаарын байдлыг харгалзан өвлийн, зуны улирал гэсэн хоёр төрөлтэй байна. Өвлийн ажлын тусгай хувцсыг 10-р сарын 01-ний өдрөөс 04-р сарын 01-ний өдрийн хооронд 6 сар, зуны ажлын тусгай хувцсыг 04-р сарын 01-ний өдрөөс 10-р сарын 01-ний өдрийн хооронд 6 сар хэрэглэнэ.

2.2 Ажлын тусгай хувцасны эдэлгээний хугацааг 2-3 жилээр /12-18 сар/ тогтоох ба хөдөлмөрийн нөхцөл, ажил мэргэжлийн онцлогоос хамаарч 6-12 сараар тогтоож болно.

2.3 Ажилтан бурд ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл тавьж олгосон эдэлгээний хугацааг заасан карт /хүснэгт №4/-ыг байгууллагын тооцооны нягтлан бодох бүртгэлийн ажилтан хөтөлнө.

2.4 Тусгай зориулалтын /химийн хорт бодисоос хамгаалах/ болон борооны цув, усны гутал, өндрийн хамгаалалтын бүс, цахилгаанаас хамгаалах резинэн бээлий зэрэг тусгай хувцас хамгаалах хэрэгслийг ажлын байранд картаар олгох бөгөөд тухайн ажилтан бүрэн бүтэн байдалд хяналт тавих бөгөөд эдэлгээ хэрэглээнд ХАБЭА-н зөвлөл хяналт тавина.

2.5 Ажлын онцлогоос хамааран нүдний салст гэмтэх, нүдэнд гаднын биет орох нөхцөл бүхий ажлын байранд нүдний шил олгох бөгөөд ажилтан бүрэн бүтэн байдалд хяналт тавих бөгөөд эдэлгээ хэрэглээнд ХАБЭА-н зөвлөл хяналт тавина.

2.6 Эсгий гутал, усны гутал, борооны цув 3 жил /18 сар/-ийн хугацаатай олгож тухайн ажилтан түүний бүрэн бүтэн байдлыг хариуцна. Эдэлгээ, хэрэглээнд ХАБЭА-н зөвлөл хяналт тавина.

2.7 Байгууллага нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг хүчин зүйлсийг арилгах, ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор элэгдлээр хэрэглэгдэх хамгаалах хэрэгслийр ажилтныг тасралтгүй хангах үүрэг хүлээнэ. Элэгдлээр хэрэглэгдэх хамгаалах хэрэгслийн нөөцийг ажлын байранд байрлуулах бөгөөд хэмжээ, тоо ширхэг, хариуцагчийг байгууллагын захирлын шийдвэрээр тогтооно. Ажилтан элэгдлээр хэрэглэгдэх хамгаалах хэрэгсэл дахин авч ашиглах тохиолдолд зарцуулалт хөтлөх дэвтэрт бүртгэл хөтөлж ашиглагдсан хамгаалах хэрэгслийг тусгайлан бэлдсэн хайрцагт хийнэ. Аж ахуйн нярав сар бүр зарцуулалтын тайланг хагас жилээр гаргаж Ерөнхий нягтлан бодогч, ХАБЭА-н ажилтанд танилцуулах.

2.8 Байгууллага нь хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан болон дуусгавар болгосон ажилтны ажлын тусгай хувцсыг хураан авч, ангилал хийж цаашид хэрэглэх боломжтой ажлын өмд, цамцыг ариутган цэвэрлэн хадгалж, шинэ ажилтны туршилтын хугацаанд, түр ажилтан, дадлагын оюутнуудад олгоно.

2.9 Байгууллага нь хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан болон дуусгавар болгосон ажилтны ажлын гутлыг акт тогтоон устгалд оруулна.

2.10 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл нь эдэлгээний хугацаандаа хүрээгүй элэгдэж шаардлага хангахааргүй болсон тохиолдолд ажилтны өргөдөл хүсэлтийг үндэслэн байгууллагын захиргаа комисс томилон акт тогтоон нөхөн олгох ажлыг зохион байгуулна. Өргөдөл, актын загвар аж ахуйн няравт байна.

2.11 Байгууллага нь ажилтанд ажлын тусгай хувцас, гутлын олголт хийсний дараагаар ахуйн байрны эмх, цэгц, ариун цэврийг хангах зорилгоор эдэлгээний хугацаа дууссан

ажлын тусгай хувцас, гутлыг ажил олгогчийн шийдвэрээр комисс гарган хураан авч устгалд оруулах буюу цэвэрлэн хадгална.

**ГУРАВ. АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС, ХАМГААЛАХ ХЭРЭГСЛЭЭР ХАНГАХ
АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

3.1 Байгууллагын тооцооны нягтлан нь ажлын тусгай хувцас, гутлын карт, хүснэгт №4-ийг үндэслэн хүснэгт №1-р зуны ажлын тусгай хувцас, гутлын захиалгыг 02-р сарын 01-ний дотор, хүснэгт №2-р өвлийн ажлын тусгай хувцас, гутлын захиалгыг 08-р сарын 01-ний дотор гаргаж аж ахуйн няравт өгсөн байна.

3.2 Байгууллагын ХАБЭА-н ажилтан 20... онд шаардлагатай хамгаалах хэрэгслийн захиалгыг хүснэгт №3-р гаргаж 01-р сарын 10-ны дотор аж ахуйн няравт гаргаж өгсөн байна.

3.3 Байгууллагын захирлын томилсон комисс /ХАБЭА-н ажилтан, аж ахуйн нярав, ажилтны төлөөлөл/ нь ажилтан нарыг 04-р сарын 01-ны дотор зуны ажлын тусгай хувцсаар, 10-р сарын 01-ний дотор өвлийн ажлын тусгай хувцсаар, хамгаалах хэрэгслийг захиалгын дагуу хангасан байна.

3.4 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл худалдан авахдаа чанарын гэрчилгээ болон холбогдох эрх зүйн баримт бичгийг хувилан авсан байна.

3.5 Байгууллага нь ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл худалдан авахдаа ажилтнуудаас авсан санал дээр үндэслэнэ.

3.6 Ажилтан нарт олгох ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг татан авах, олгоход ажилтны төлөөллийг заавал оролцуулна.

3.7 Байгууллага нь ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийн хангамжийн ажлыг Монгол Улсын хууль тогтоомж, зөвлөмжийг баримтлан зохион байгуулна.

**ДӨРӨВ. АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН
ЦЭВЭРЛЭГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭ**

4.1 Ажилтан нар нь ажил дууссаны дараа бохирдсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг тусгайллан бэлдсэн сагс /сав/-нд хийж тавьсан байна.

4.2 Байгууллагын үйлчлэгч нь ажилтны ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан хийнэ.

4.3 Байгууллага нь ажилтны ажлын тусгай хувцаснаас бусад хувцас хэрэгслийг угааж цэвэрлэхгүй бөгөөд ажлын хувцасны угаалга цэвэрлэгээ сард 2 удаа графикийн дагуу

хийгдэнэ. Ажлын ачааллаас шалтгаалан захиргааны шийдвэрээр ажлын хувцас угааж, ариутгаж болно.

ТАВХАРИУЦЛАГА

5.1 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зүй зохистой хэрэглэх, ажлын байранд өмсүүлж хэвшүүлэхэд ХАБЭА-н зөвлөл байнгын хяналт тавьж ажиллана.

5.2 Ажилтан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зөвхөн ажлын үед хэрэглэнэ. Олгогдсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг хайрлан хамгаалж, бүрэн бутэн байдлыг хангаж ажиллана.

5.3 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу өмсөх хэрэглэхгүй байх, гэрлүүгээ өсөж явах, ажилчдын автомашин, байгууллагын бусад албан контор, хурлын танхимд орж суухыг хориглох бөгөөд энэ нь үр дүнгийн шагнал хасах үндэслэл болно.

5.4 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтан дур мэдэн зарж борлуулахыг хориглоно. Зарж борлуулсан тохиолдолд захиргааны шийдвэрээр үнийг 3 дахин нэмэгдүүлж төлүүлэх буюу сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.

5.5 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг хугацаанд нь татан авч олгоогүй, захиалга хангамжийн судалгааг гаргаж өгөөгүй, чанар, стандартын шаардлага хангахгүй ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл татан авсан, ажилтан нарын саналыг тусгахгүй дур мэдэн татан авалт хийсэн, ашиг хонжоо олох зорилгоор өөрийн эрх мэдлийг хэтрүүлсэн нь тогтоогдсон зэрэг нь буруутай ажилтанд сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.

Дөрөвдүгээр сарын 01-ний өдрийн дотор хангалт хийх шаардлагатай ажлын тусгай хувцасны захиалга

№	Ажлын тусгай хувцасны нэр	Өмсгэл						Тоо ширхэг	Тайлбар
		46	48	50	52	54	56		
	Зуны ажлын хувцас								
		36	37	38	39	40	41		
	Зуны ажлын гутал								
Нэмэт захиалга									
		46	48	50	52	54	56		
	Зуны ажлын хувцас								
		36	37	38	39	40	41		
	Зуны ажлын гутал								

Хянаж зөвшөөрсөн: тамга

Захирал/...../.....

Ерөнхий нягтлан бодогч...../...../.....

ХАБЭА-н ажилтан...../...../.....

Захиалга гаргасан:

Тооцооны нягтлан...../...../.....

Захиалга авсан:

Аж ахуйн нярав...../...../.....

..... он..... сар..... өдөр

Аравдугаар сарын 01-ний өдрийн дотор хангалт хийх шаардлагатай ажлын
тусгай хувцасны захиалга

№	Ажлын тусгай хувцасны нэр	Өмсгөл						Тоо ширхэг	Тайлбар
		46	48	50	52	54	56		
	Өвлийн ажлын хувцас								
		36	37	38	39	40	41		
	Өвлийн ажлын гутал								
Нэмэг зөвшүүрсэн:									
		46	48	50	52	54	56		
	Өвлийн ажлын хувцас								
		36	37	38	39	40	41		
	Өвлийн ажлын гутал								

Хянаж зөвшүүрсэн:
тамга

Захирал /

Ерөнхий нягтлан бодогч..... /

ХАБЭА-н ажилтан..... /

Захиалга гаргасан:

Тооцооны нягтлан..... /

Захиалга авсан:

Аж ахуйн нярав..... /

..... он..... сар..... өдөр

20....онд шаардлагатай хамгаалах хэрэгслийн захиалга

№	Хамгаалах хэрэгслийн нэр	Татан авах хугацаа		Нийт тоо ширхэг	Тайлбар
		IV/01-ний дотор	X/01-ний дотор		
1	Хамгаалах дуулга				
2	Дохионы хантааз				
3	Ажлын бээлий				
...	Бусад хамгаалах хэрэгслийг Олон улсын болон Монгол улсад мөрдөж байгаа стандартаар захиална.				

Хянаж зөвшөөрсөн: тамга

Захирал /

Ерөнхий нягтлан бодогч..... /

Захиалга гаргасан:

ХАБЭА-н ажилтан..... /

Захиалга авсан:

Аж ахуйн нярав..... /

..... он..... сар..... өдөр

**АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС, ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ
ОЛГОСОН КАРТ**

Байгууллагын нэр.....

Овог Нэр

Албан тушаал.....

Размер: хувцас Гутал.....

№	Олгосон барааны нэр	Эдэлгээний хугацаа		Олголт он, сар, өдөр				Буцаалт	Гарын үсэг
		Cap	Жил	Он, сар, өдөр					
				Он, сар, өдөр					
				Үнэ					
				размер					

Хөтөлсөн: тооцооны нягтлан:.....

Хянасан: ХАБЭА-н ажилтан.....

**ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН ЗАРЦУУЛАЛТ ХӨТЛӨХ
ДЭВТРИЙН ЗАГВАР**

Д/Д	Овог нэр	Албан тушаал	Сар, өдөр	Ашигласан хамгаалах хэрэгслийн нэр	Зориулалт	Гарын үсэг
1						
2						
3						
4						
5						

ӨРГӨДӨЛ

.....он.....сар.....өдөр
Замын-Үүд

Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж төрийн өмчит аж ахуйн тооцoot үйлдвэрийн
газарт.....

.....овогтойминий ашиглаж байсан

НЬ

ажлын
явлад.....

цаашид ашиглах боломжгүй болсон тул акт тогтоож, шинээр олгож өгнө үү.

Өргөдөл гаргасан...../

/

АЖЛЫН ХУВЦАС, ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН
АКТ

.....он.....сар..... ёдөр

Замын-Үүд

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж тэрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгсэл актлах комисс:

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж тэрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт.....ажилтай

.....овогтой.....нд.....оны.....-р
сарын.....-ний ёдөр олгосон.....-г
шалган үзэхэд:

.....байлаа.

Комиссийн дүгнэлт:

Комиссийн дарга:...../

Гишүүд:...../

...../

/

...../

/

...../

/

“ШТШАБ” ТӨААТҮГ-ЫН ЗАХИРЛЫН ~~12~~¹³ ОНЫ ~~16~~¹⁷ САРЫН
12..НЫ ӨДРИЙН ~~1/2~~^{1/3} ДУГААР ТУШААЛЫН ХОЁРДУГААР ХАВСРАЛТ

**АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС, ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ ОЛГОХ ЖАГСААЛТ,
ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЦАА**

Д/Д	Албан тушаалын ангилаал	Хэмжих нэгж	Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийн нэр төрөл	Олгогдох хэмжээ /ширхэг/	Хэрэглэх хугацаа /сар/
1	Байгууллагын захирал	Хос	Өвлийн ажлын хувцас	1	18
		Хос	Өвлийн ажлын гутал	1	18
		Хос	Зуны ажлын хувцас	1	18
		Хос	Зуны ажлын гутал	1	18
		Ширхэг	Дуулга	1	18
2	Ерөнхий инженер	Хос	Өвлийн ажлын хувцас	1	18
		Хос	Өвлийн ажлын гутал	1	18
		Хос	Зуны ажлын хувцас	1	18
		Хос	Зуны ажлын гутал	1	18
		Ширхэг	Бээлий	2	Элэгдлээр
		Ширхэг	Дуулга	1	18
3	Ерөнхий нягтлан бодогч	Хос	Зуны ажлын хувцас	1	18
4	Технологийн инженер	Хос	Өвлийн ажлын хувцас	1	18
		Хос	Өвлийн ажлын гутал	1	18
		Хос	Зуны ажлын хувцас	1	18
		Хос	Зуны ажлын гутал	1	18
		Ширхэг	Бээлий	5	Элэгдлээр
		Ширхэг	Дуулга	1	18
5	Дотоод хяналтын ажилтан	Хос	Өвлийн ажлын хувцас	1	18
		Хос	Өвлийн ажлын гутал	1	18
		Хос	Зуны ажлын хувцас	1	18
		Хос	Зуны ажлын гутал	1	18
		Ширхэг	Бээлий	2	Элэгдлээр
		Ширхэг	Дуулга	1	18
6	ХАБЭА-н ажилтан	Хос	Өвлийн ажлын хувцас	1	18
		Хос	Өвлийн ажлын гутал	1	18
		Хос	Зуны ажлын хувцас	1	18
		Хос	Зуны ажлын гутал	1	18
		Ширхэг	Бээлий	2	Элэгдлээр
		Ширхэг	Дуулга	1	18
7	Эдийн засагч	Хос	Зуны ажлын хувцас	1	18
8	Бичиг хэрэг	Хос	Зуны ажлын хувцас	1	18
9	Тооцооны нягтлан	Хос	Зуны ажлын хувцас	1	18
10	Аж ахуйн нарав	Хос	Өвлийн ажлын хувцас	1	18
		Хос	Өвлийн ажлын гутал	1	18
		Хос	Зуны ажлын хувцас	1	18
		Хос	Зуны ажлын гутал	1	18
		Ширхэг	Дуулга	1	18
		Ширхэг	Бээлий	2	Элэгдлээр
11	Шатахууны	Хос	Өвлийн ажлын хувцас	1	12

	Нярав	Хос	Өвлийн ажлын гутал	1	12
		Хос	Зуны ажлын хувцас	1	12
		Хос	Зуны ажлын гутал	1	12
		Ширхэг	Дуулга	1	12
		Ширхэг	Бээлий	5	Элэгдлээр
		Ширхэг	Хошуувч	1	Элэгдлээр
		Ширхэг	Нүдний шил	1	Элэгдлээр
		Ширхэг	Нэг удаагийн бээлий	10	Элэгдлээр
12	Лабораторийн эрхлэгч	Хос	Өвлийн ажлын хувцас	1	18
		Хос	Өвлийн ажлын гутал	1	18
		Хос	Зуны ажлын хувцас	1	18
		Хос	Зуны ажлын гутал	1	18
		Ширхэг	Дуулга	1	18
		Ширхэг	Халад	1	Элэгдлээр
		Ширхэг	Бээлий	2	Элэгдлээр
13	Шинжээч мэргэжилтэн	Хос	Өвлийн ажлын хувцас	1	18
		Хос	Өвлийн ажлын гутал	1	18
		Хос	Зуны ажлын хувцас	1	18
		Хос	Зуны ажлын гутал	1	18
		Хос	Тусгай зориулалтын гутал	1	12
		Ширхэг	Дуулга	1	18
		Ширхэг	Халад	1	Элэгдлээр
14	С.Т.Т-ийн оператор	Ширхэг	Нүдний шил	1	Элэгдлээр
		Ширхэг	Бээлий	5	Элэгдлээр
		Ширхэг	Нэг удаагийн бээлий	5	Элэгдлээр
		Хос	Өвлийн ажлын хувцас	1	12
		Хос	Өвлийн ажлын гутал	1	12
		Хос	Зуны ажлын хувцас	1	12
		Хос	Зуны ажлын гутал	1	12
15	Засварчин	Ширхэг	Дуулга	1	18
		Ширхэг	Бээлий	5	Элэгдлээр
		Ширхэг	Нүдний шил	1	Элэгдлээр
		Ширхэг	Хошуувч	1	Элэгдлээр
		Хос	Өвлийн ажлын хувцас	1	12
		Хос	Өвлийн ажлын гутал	1	12
		Хос	Зуны ажлын хувцас	1	12
16	Цахилгаанчин	Хос	Зуны ажлын гутал	1	12
		Хос	Гагнуурын бирзентэн хувцас	1	18
		Ширхэг	Дуулга	1	18
		Ширхэг	Бээлий	2	Элэгдлээр
		Хос	Өвлийн ажлын хувцас	1	12
		Хос	Өвлийн ажлын гутал	1	12
		Хос	Зуны ажлын хувцас	1	12
17	Сантехник	Хос	Зуны ажлын гутал	1	12
		Хос	Гагнуурын бирзентэн хувцас	1	18
		Ширхэг	Дуулга	1	18
		Ширхэг	Бээлий	5	Элэгдлээр
		Хос	Өвлийн ажлын хувцас	1	12
		Хос	Өвлийн ажлын гутал	1	12
		Хос	Зуны ажлын хувцас	1	12
18	Ачигч буулгагч	Хос	Зуны ажлын гутал	1	12
		Хос	Зуны ажлын хувцас	1	12
		Хос	Зуны ажлын гутал	1	12
		Хос	Зуны ажлын гутал	1	12

		Ширхэг	Дуулга	1	18
		Ширхэг	Бээлий	5	Элэгдлээр
		Ширхэг	Нүдний шил	1	Элэгдлээр
19	Харуул	Хос	Өвлийн ажлын хувцас	1	12
		Хос	Өвлийн ажлын гутал	1	12
		Хос	Зуны ажлын хувцас	1	12
		Хос	Зуны ажлын гутал	1	12
		Ширхэг	Дуулга	1	18
		Ширхэг	Бээлий	2	Элэгдлээр
		Ширхэг	Нүдний шил	1	Элэгдлээр
		Хос	Өвлийн ажлын хувцас	1	12
20	Жолооч	Хос	Өвлийн ажлын гутал	1	12
		Хос	Зуны ажлын хувцас	1	12
		Хос	Зуны ажлын гутал	1	12
		Ширхэг	Бээлий	2	Элэгдлээр
		Ширхэг	Нүдний шил	1	Элэгдлээр
		Хос	Ажлын хувцас	1	12
21	Тогооч	Хос	Ажлын гутал	1	12
		Ширхэг	Нэг удаагийн бээлий	10	Элэгдлээр
		Хос	Ажлын хувцас	1	12
22	Үйлчлэгч	Хос	Ажлын гутал	1	12
		Ширхэг	Резинэн бээлий	2	Элэгдлээр

**ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ХУВЦАС, ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН
ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЦАА**

Д/Д	Тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр	төо	Хэрэглэх хугацаа /жилээр/
1	Сав цэвэрлэгээний тусгай хувцас	2	3
2	Сав цэвэрлэгээний баг хоолой	2	3